АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2023/95-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Н.Алтантуяа<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.07 № 02

танай ____________-ны № ____________-т

ХАЙРХАН СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу .Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт гаргах үндэслэл болно. Үүнд:

1. Хайрхан сумын ЗДТГазар нь 2022 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO стандарт нэвтрүүлэхээр "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-тай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний гарын үсгийн бүрдэлгүй, эх хувь гэрээгүй, ажлын даалгаварт заагдсан ажлууд дутуу хийгдэж, зөвлөх үйлчилгээний ажлыг баталгаажуулаагүй байхад 17,983.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн.
2. Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын засаг даргын нэрэмжит тэмцээн, уралдааны шагналд нийт 4,269.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
3. Мал амьтдын бүртгэл дэх 190 толгой бог малыг нас дэвшүүлж бүртгэхдээ 2,974.0 мянган төгрөгөөр буюу нэг толгой малыг 15.6 мянган төгрөгөөр буюу зах зээлийн үнээс хэт доогуур үнэлж бүртгэсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Стандарттай Архангай" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар болон төрийн байгууллагуудад Чанарын удирдлагын

003020049

тогтолцоо (ISO-9001:2015)-г нэвтрүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд Хайрхан сумын ЗДТГазар нь 2022 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO стандартыг нэвтрүүлж эхэлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллагын төсөв захирагч нь 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн б/25 тоот сумын засаг даргын захирамжаар даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилжээ.

Хайрхан сумын ЗДТГ-т 2019-2022 онуудад төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр 5-н албан хаагч томилогдон ажиллаж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 үндсэн зорилт, 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 93.7 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 51,428,862.00 | 55,875,862.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 51,428,862.00 | 55,875,862.00 |
| 35100 | Түүхий эд материал | 1,950,500.00 | 1,950,500.00 |
| 35130 | Эм боох материал | 1,950,500.00 | 1,950,500.00 |
| 35400 | Хангамжийн материал | 37,632,362.00 | 42,449,362.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,839,275.00 | 2,469,775.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,099,879.00 | 8,269,879.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 15,108.00 | 15,108.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 973,100.00 | 973,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 27,705,000.00 | 30,721,500.00 |
| 35600 | Мал амьтад | 11,846,000.00 | 11,476,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,009,048,161.68 | 2,202,247,797.07 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,009,048,161.68 | 2,202,247,797.07 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,992,368,161.68 | 2,179,967,797.07 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 875,810,800.14 | 972,133,341.14 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -58,986,275.55 | -97,534,208.55 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 97,344,800.00 | 121,854,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -57,035,188.86 | -50,323,488.80 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 255,781,616.34 | 232,548,716.34 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -145,620,699.13 | -153,478,123.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 79,937,599.00 | 70,620,458.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -47,857,042.13 | -41,913,773.34 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 20,847,200.00 | 20,847,200.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,403,706,025.00 | 1,673,256,972.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -469,666,273.13 | -568,044,096.72 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 38,105,600.00 | 0.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 16,680,000.00 | 22,280,000.00 |
| 39301 | Програм хангамж | 5,500,000.00 | 5,500,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,180,000.00 | 16,780,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,060,477,023.68 | 2,258,123,659.07 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,060,477,023.68 | 2,258,123,659.07 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,060,477,023.68 | 2,258,123,659.07 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 448,116,428.17 | 448,116,428.17 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 448,116,428.17 | 448,116,428.17 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,066,245,141.96 | 1,263,891,777.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 945,101,190.87 | 1,066,245,141.96 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 121,143,951.09 | 197,646,635.39 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 546,115,453.55 | 546,115,453.55 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,060,477,023.68 | 2,258,123,659.07 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 726,551,892.00 | 921,072,006.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 209,792,279.00 | 418,152,488.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 187,884,279.00 | 418,152,488.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,018,000.00 | 3,295,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,018,000.00 | 3,295,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 171,565,279.00 | 403,383,488.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 13,301,000.00 | 11,474,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | 21,908,000.00 | |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 21,908,000.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 516,759,613.00 | 502,919,518.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 58,635,413.00 | 23,281,018.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 17,098,940.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 418,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 41,536,473.00 | 10,847,718.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 12,015,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 458,124,200.00 | 479,638,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 458,124,200.00 | 479,638,500.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 605,407,940.91 | 704,814,561.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 605,407,940.91 | 704,814,561.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 589,281,554.91 | 649,491,342.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 227,235,850.00 | 228,097,256.00 |
| 210101 | Үндсэн цалин | 227,235,850.00 | 228,097,256.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,553,699.00 | 28,385,806.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,478,191.00 | 19,328,853.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,276,550.00 | 2,277,948.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,816,955.00 | 1,822,357.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 439,610.00 | 445,436.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,542,393.00 | 4,511,212.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 90,686,896.00 | 94,386,066.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,784,458.00 | 7,415,433.00 |
| 210302 | Түлш, халаалт | 86,797,096.00 | 86,860,633.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 105,342.00 | 110,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,123,040.00 | 19,666,080.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,382,600.00 | 2,298,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,113,980.00 | 12,036,645.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,606,000.00 | 3,858,535.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 216,000.00 | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,929,910.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,772,400.00 | 1,081,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,102,150.00 | 271,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 660,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,620,000.00 | 759,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,620,000.00 | 759,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,488,000.00 | 2,150,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,488,000.00 | 2,150,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,141,747.00 | 33,099,326.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,109,213.00 | 32,655,368.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 259,545.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,634.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 88,000.00 | 75,738.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 27,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 199,772,322.91 | 242,947,308.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,603,865.00 | 51,374,265.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 91,168,457.91 | 191,573,043.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,126,386.00 | 55,323,219.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,440,000.00 | 42,220,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 0.00 | 12,859,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 28,316,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,440,000.00 | 1,045,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 14,686,386.00 | 13,102,619.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,614,981.00 | 11,738,679.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 9,071,405.00 | 1,363,940.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 121,143,951.09 | 216,257,444.01 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 18,610,808.62 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0.00 | 18,610,808.62 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 121,143,951.09 | 197,646,635.39 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 542,812,533.00 | 506,214,518.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,144,920.00 | 3,295,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,144,920.00 | 3,295,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,144,920.00 | 3,295,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,144,920.00 | 3,295,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 538,667,613.00 | 502,919,518.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 80,543,413.00 | 23,281,018.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 21,908,000.00 | 0.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 418,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 41,536,473.00 | 10,847,718.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,098,940.00 | 12,015,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 458,124,200.00 | 479,638,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 458,124,200.00 | 479,638,500.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 476,303,933.00 | 506,214,518.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 476,303,933.00 | 506,214,518.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 460,177,547.00 | 450,941,299.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 227,245,210.00 | 228,097,256.00 |
| 210101 | Үндсэн цалин | 227,245,210.00 | 204,245,445.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 20,673,657.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 3,178,154.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,553,699.00 | 28,385,806.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,478,191.00 | 19,328,853.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,276,550.00 | 2,277,948.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,816,955.00 | 1,822,357.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 439,610.00 | 445,436.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,542,393.00 | 4,511,212.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 90,686,896.00 | 94,386,066.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,784,458.00 | 7,415,433.00 |
| 210302 | Түлш, халаалт | 86,797,096.00 | 86,860,633.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 105,342.00 | 110,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,838,290.00 | 19,587,580.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,195,000.00 | 2,490,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,113,980.00 | 12,036,645.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,606,000.00 | 3,858,535.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 321,000.00 | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,929,910.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,672,400.00 | 1,081,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,119,000.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,119,000.00 | 0.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 0.00 | 759,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 759,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,488,000.00 | 2,150,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,488,000.00 | 2,150,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,141,747.00 | 33,537,326.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,109,213.00 | 33,093,368.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 259,545.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,634.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 88,000.00 | 75,738.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 27,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 104,900.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,104,705.00 | 44,037,765.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,104,705.00 | 44,037,765.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,126,386.00 | 55,273,219.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,440,000.00 | 42,170,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 0.00 | 12,859,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 28,316,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,440,000.00 | 995,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 14,686,386.00 | 13,102,619.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,614,981.00 | 11,738,679.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 9,071,405.00 | 1,363,940.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 66,508,600.00 | 0.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 66,508,600.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 66,508,600.00 | 0.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 66,508,600.00 | 0.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 66,508,600.00 | 0.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -66,508,600.00 | 0.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0.00 | 0.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 448,116,428.17 | 546,115,453.55 | 945,101,190.87 | 1,939,333,072.59 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 448,116,428.17 | 546,115,453.55 | 945,101,190.87 | 1,939,333,072.59 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 121,143,951.09 | 121,143,951.09 |
| 5 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 448,116,428.17 | 546,115,453.55 | 1,066,245,141.96 | 2,060,477,023.68 |
| 6 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 448,116,428.17 | 546,115,453.55 | 1,066,245,141.96 | 2,060,477,023.68 |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 448,116,428.17 | 546,115,453.55 | 1,066,245,141.96 | 2,060,477,023.68 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 197,646,635.39 | 197,646,635.39 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 448,116,428.17 | 546,115,453.55 | 1,263,891,777.35 | 2,258,123,659.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 489,138,500.00 | 471,194,821.00 | 17,943,679.00 | 96.33 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 489,138,500.00 | 471,194,821.00 | 17,943,679.00 | 96.33 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 446,962,900.00 | 429,024,221.00 | 17,938,679.00 | 95.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 234,684,200.00 | 228,097,256.00 | 6,586,944.00 | 97.19 |
| 210101 | Үндсэн цалин | 234,684,200.00 | 204,245,445.00 | 30,438,755.00 | 87.03 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 20,673,657.00 | -20,673,657.00 | #DIV/0! |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 3,178,154.00 | -3,178,154.00 | #DIV/0! |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,335,500.00 | 28,385,806.00 | 949,694.00 | 96.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,948,000.00 | 19,328,853.00 | 619,147.00 | 96.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,346,900.00 | 2,277,948.00 | 68,952.00 | 97.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,877,500.00 | 1,822,357.00 | 55,143.00 | 97.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,400.00 | 445,436.00 | 23,964.00 | 94.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,693,700.00 | 4,511,212.00 | 182,488.00 | 96.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 95,950,000.00 | 94,386,066.00 | 1,563,934.00 | 98.37 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,850,000.00 | 7,415,433.00 | 1,434,567.00 | 83.79 |
| 210302 | Түлш, халаалт | 86,900,000.00 | 86,860,633.00 | 39,367.00 | 99.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 110,000.00 | 90,000.00 | 55.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,686,100.00 | 19,587,580.00 | 98,520.00 | 99.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,500,000.00 | 2,490,800.00 | 9,200.00 | 99.63 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,120,000.00 | 12,036,645.00 | 83,355.00 | 99.31 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,863,600.00 | 3,858,535.00 | 5,065.00 | 99.87 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 120,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,082,500.00 | 1,081,600.00 | 900.00 | 99.92 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 790,000.00 | 759,500.00 | 30,500.00 | 96.14 |
| 210604 | Урсгал засвар | 790,000.00 | 759,500.00 | 30,500.00 | 96.14 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,150,000.00 | 2,150,000.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,150,000.00 | 2,150,000.00 | 0.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,867,100.00 | 32,061,013.00 | 5,806,087.00 | 84.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,257,100.00 | 31,617,055.00 | 5,640,045.00 | 84.86 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000.00 | 259,545.00 | 20,455.00 | 92.69 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 190,000.00 | 81,675.00 | 108,325.00 | 42.99 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 85,000.00 | 75,738.00 | 9,262.00 | 89.10 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 27,000.00 | 28,000.00 | 49.09 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,500,000.00 | 23,597,000.00 | 2,903,000.00 | 89.05 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,500,000.00 | 23,597,000.00 | 2,903,000.00 | 89.05 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,175,600.00 | 42,170,600.00 | 5,000.00 | 99.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 42,175,600.00 | 42,170,600.00 | 5,000.00 | 99.99 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,859,000.00 | 12,859,000.00 | 0.00 | 100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,316,600.00 | 28,316,600.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 995,000.00 | 5,000.00 | 99.50 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 489,138,500.00 | 471,194,821.00 | 17,943,679.00 | 96.33 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 479,638,500.00 | 467,899,821.00 | 11,738,679.00 | 99.23 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 479,638,500.00 | 467,899,821.00 | 11,738,679.00 | 97.55 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 9,500,000.00 | 3,295,000.00 | 6,205,000.00 | 34.68 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,500,000.00 | 3,295,000.00 | 6,205,000.00 | 34.68 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 25.00 | 25.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 7.00 | 7.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 23,281,018.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 23,281,018.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 23,281,018.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,476,313.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,476,313.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,440,765.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,440,765.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,363,940.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,363,940.00 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,363,940.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 23,281,018.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 23,281,018.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 418,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,847,718.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,015,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй, харин залруулагдаагүй нийт 37,622.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 37,622.0 мянган төгрөгт 4 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Тус байгууллага нь 2022 онд 17,983.0 мянган төгрөгөөр Чанарын менежментийн тогтолцооны ISO стандарт нэвтрүүлэхээр “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний гарын үсгийн бүрдэл дутуу, эх хувь гэрээгүй, ажлын даалгаварт заагдсан ажлууд дутуу хийгдэж, зөвлөх үйлчилгээний ажлыг баталгаажуулаагүй байхад төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг зөрчсөн байна

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.2 Мал амьтдын бүртгэл дэх 190 толгой бог малыг нас дэвшүүлж бүртгэхдээ 2,974.0 мянган төгрөгөөр буюу нэг толгой малыг 15.6 мянган төгрөгөөр зах зээлийн үнээс хэт доогуур үнэлж бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС -27 параграф 21-т “ ... биологийн хөрөнгө буюу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд идэвхтэй зах зээл оршин байгаа бол уг зах зээлийн жишиг үнэ нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох зохих суурь үндэслэл болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.3 БГАҮТХ-ийн зардлаас 5,457.7 мянган төгрөгийн хог тээвэрлэх зориулалт бүхий авто машины шатахуун, жолооч, ачигчийн цалин,НДШ-ийн зардалд 6,938.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190-р тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйл үйлчилгээний төлбөр хураамжийн зардал ангилалд байгууллага гуравдагч этгээдээс авах багц үйлчилгээг худалдан авахад төлөх зардлыг бүртгэнэ, хувь хүнээс ажил үйлчилгээ авсны төлөөсөнд төлж буй НДШ тооцогдох цалин хөлс, урамшуулал хамаарахгүй гэснийг зөрчсөн байна

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.4 Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад Сумын засаг даргын нэрэмжит олон төрөлтийн тэмцээний шагналд 2,959.0 мянган төгрөг, оны шилдэгүүдийн шагналд 1,310.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т " Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-т" Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1.Цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:* Цахим төлбөрийн баримт болох и-баримтыг анхан шатны баримтанд авсан эсэхийг хянаж үзэхэд нийт худалдан авалт, тогтмол зардлын гүйлгээний 30 орчим хувьд и-баримтыг анхан шатны баримтанд аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Цахим төлбөрийн баримтын гүйцэтгэлд хяналт тавьж, и-баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс шаардан авч, анхан шатны баримтыг бүрдлийг ханган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хайрхан сумын ЗДТГ | 5 | 37622.0 | 0 | 0 | 4 | 37622.0 | 1 | 0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хайрхан сумын ЗДТГ | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |